



ДУНДГОВЬ АЙМАГ
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 4/27

Тавин

Дуудлага худалдаа зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Адаацаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 24 дүгээр тогтоолоор батлагдсан 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу иргэн Аж ахуй нэгж байгууллагад шинээр эзэмшүүлэх газрын дуудлага худалдаа явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Адаацаг сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Хөтлөгч: Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын

захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Тэмдэглэл хөтлөгч: Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын

Газрын кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Газар эзэмших эрхийн дуудлага худалдаа явуулах ажлын журам, зааврыг баримтлан ил тод, нээлттэй явуулахыг ажлын хэсгийн ахлагч Газар зохион байгуулалт, төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэнд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.УРАНЧИМЭГ